

**ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН  
ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН  
СУДАЛСАН ТУХАЙ**

# **ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН ТУХАЙ**

## ***Нэг. Асуудалд дүн шинжилгээ хийх***

### **1.1 Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал:**

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль нь 2001 оны 2-р сарын 01-ний өдөр батлагдсанаас хойш хугацаанд тус хуульд 68 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байдаг.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нийт 19 чиглэлээр 104 нэр төрлийн тусгай зөвшөөрөл олгохоор тогтоосон. Гэвч өнөөдрийн байдлаар Монгол Улсын хэмжээнд зөвшөөрлийн ерөнхий төрлийг салбарын бусад хууль тогтоомж, эрх зүйн актаар задалж, тусгай зөвшөөрийг шинээр бий болгон эрх бүхий 54 байгууллагаас 900 гаруй төрлийн тусгай зөвшөөрөл олгож байна.

Ийнхүү яам, агентлаг хуульд заасан тусгай зөвшөөрлийг олгох журам батлан гаргахдаа нэг зөвшөөрлийг дотор нь задлах, олон болгох, цаашилбал тусгай зөвшөөрөл олгохтой холбоотойгоор нэмэлт нөхцөл, шаардлага тавих зэргээр зөвшөөрлийн төрөл, хамрах хүрээ, бүрдүүлэх баримт бичиг, хангах шаардлага нөхцөлийг хэт өргөжүүлдэг практик тогтсон байна. Энэ нь бизнес эрхлэгчдэд дарамт учруулах, хүнд суртал, авлига үүсэх гол шалтгаан болж байгаа юм.

Уг асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлохдоо тусгай зөвшөөрлийг олгохтой холбогдсон нөхцөл байдлын талаарх лавлагаа, статистик тоон мэдээлэл цуглуулах, мөн асуудал хариуцсан мэргэжилтэн, бизнес эрхлэгчдийн төлөөлөлтэй ярилцлага хийх, эрх зүйн акт, энэ асуудлаар өмнө хийгдсэн судалгаа, тодорхой тохиолдлыг судлах хэлбэрээр чанарын мэдээлэл цуглуулсан болно.

### **Эрх зүйн зохицуулалт:**

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 1.19-д “Төрөөс бизнес эрхлэгчдэд олгож байгаа тусгай зөвшөөрлийн тоог гурав дахин цөөрүүлж, хүчинтэй байх хугацааг уртасган, давхардсан хяналт шалгалт, хүнд суртлыг арилгана.”, 2.62-т “Уул уурхайн үйлдвэрлэл дэх төрийн оролцоог зохистой хэмжээнд байлгаж, Кадастрын бүртгэлийн системийг боловсронгуй болгож, тусгай зөвшөөрөл олгох үйлчилгээг хөнгөн шуурхай болгоно.”, 5.2.7-д “Төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, хүнд суртлаас ангид байх эрх зүйн орчинг бүрдүүлж, иргэдийн эрхийг баталгаажуулна.” гэсэн зорилтуудыг тус тус дэвшүүлсэн.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2016 оны 71 дүгээр тогтоолоор батлагдсан “Эдийн засгийн сэргээх хөтөлбөр”-ийн 2.3.7-д “Төрөөс бизнес эрхлэгчдэд олгож байгаа тусгай зөвшөөрлийн тоог гурав дахин цөөрүүлж, мэргэжлийн хяналт, татвар, нийгмийн даатгал, хууль хяналтын байгууллагын давхардсан хяналт шалгалт, хүнд суртлыг арилгах”-аар заасан.

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 2-т Зөвшөөрлийн тухай хуулийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хариуцан боловсруулахаар заасан нь хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

### **Практик хэрэгжилтийн байдал:**

- Зөвшөөрлийн хамрах хүрээг өргөжүүлэх, задлах, эрх бүхий этгээд дур зоргоор элдэв баримт бичиг шаардахаас урьдчилан сэргийлсэн чухал ач холбогдолтой зохицуулалтыг өнөөгийн Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд оруулсан байдаг. Гэвч эдгээр зохицуулалтыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх үйл ажиллагаа хангалтгүй байгаа бөгөөд хуулийн хэрэгжилтэд хяналт тавьдаг бие даасан субъект байхгүй байна. Тус хуулийн 9.1.4-д “хуульд заасан тохиолдолд тусгай зөвшөөрөл олгох” зарчмыг тусгасан боловч энэ зарчим практикт хамгийн их зөрчигдөж байна.

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “...тусгай зөвшөөрлийг хуульд өөрөөр заагаагүй бол төрийн захиргааны холбогдох төв байгууллага” олгодог байхаар зохицуулсан ба зөвшөөрөл олгох журмыг батлан гаргах бүрэн эрхийг эдгээр байгууллагад салбарын хуулиар ихэвчлэн олгосон байна. Эрх шилжүүлэх ийм зохицуулалт нь яам, агентлагийн түвшний эрх зүйн акт давамгайлах нөхцөлийг бүрдүүлж байна. Ийнхүү яам, агентлаг хуульд заасан тусгай зөвшөөрлийг олгох журам батлан гаргахдаа нэг зөвшөөрлийг дотор нь задлах, олон болгох, цаашилбал тусгай зөвшөөрөл олгохтой холбоотойгоор нэмэлт нөхцөл, шаардлага тавих зэргээр зөвшөөрлийн төрөл, хамрах хүрээ, бүрдүүлэх баримт бичиг, хангах шаардлага нөхцөлийг хэт өргөжүүлдэг практик тогтсон байна. Энэ нь бизнес эрхлэгчдэд дарамт учруулах, хүнд суртал, авлига үүсэх гол шалтгаан болж байгаа юм.

Иймд зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагын эрх хэмжээг хуулиар нарийвчлан хязгаарлах, эрх шилжүүлэх нөхцөл, журмыг хуульд тодорхой тусгах, хууль хоорондын болон хууль ба төрийн захиргааны байгууллагын эрх зүйн акт хоорондын харилцан уялдааг хангах шаардлагатай байна.

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д “тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагааг тогтоосон хугацаа, нөхцөл, шаардлагын дагуу эрхлэн явуулах эрхийг иргэн, ашгийн болон ашгийн бус хуулийн этгээдэд эрх бүхий байгууллагаас олгосон албан ёсны баримт бичиг”-ийг тусгай зөвшөөрөл гэж тодорхойлсон. Гэвч гэрээ, батламж, бүртгэл, дүгнэлт, сертификат, гэрчилгээ, тодорхойлолт, эрх олголт, магадлан итгэмжлэл зэрэг төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэр, гарын үсгээр баталгаажсан олон төрлийн баримт бичгүүд практикт хэрэглэгдэж байна. Энэ нь албан бус олон тооны зөвшөөрөл бий болох, эдгээр зөвшөөрлийг олгодог эрх зүйн зохицуулалт дутагдах, оронд нь захиргааны байгууллагын журам, заавар үйлчлэх зохисгүй хандлага тогтоход хүргэжээ.

Түүнчлэн зөвшөөрлийн тодорхой нэр төрлийг тогтоож, түүний хамрах хүрээг багтаасан зохистой тодорхойлолт, хуулийн техник ашиглахгүй байгаагаас хуулийг хэрэглэхэд бэрхшээлтэй болох, зөвшөөрлийг задлах, дэд төрөлд хуваах, элдэв баримт

бичиг шаардах явдал үүсэхэд нөлөөлж байна. Жишээ нь: Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.14.6-д “барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил эрхлэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх” гэж заасан нь хэт өргөн хүрээтэй, дотроо олон төрөл болж задрах утгатай ойлгогдож, түүнийг яам, агентлагууд тодруулан задлах, ангилах тусгай журам гаргахад хүргэж байна.

Иймд зөвшөөрлийн нэр төрөл, түүний хамрах хүрээ, тодорхойлолтыг зөвхөн хуулиар тогтоож, цаашид бүртгэл, цахим боловсруулалт, мэдээ тайлангийн зориулалтаар код, дугаар ашигладаг болох шаардлагатай. Үүний үр дүнд зөвшөөрлийг нэгдсэн нэг тогтолцоонд оруулж хянах, албан бус зөвшөөрөл олголтыг арилгах боломжтой болж байгаа юм.

- Аж ахуйн үйл ажиллаганы тусгай зөвшөөрлийн тухай хууль тогтоомжоор “тусгай зөвшөөрөл” гэсэн нэг ойлголтын хүрээнд зөвшөөрлийг олгох, хянах нэг төрлийн ажиллагаа явагдаж байна. Өөрөөр хэлбэл, зөвшөөрлийн зорилго, шаардлагаас хамааруулан ангилалт хийх, уг ангилалтыг ашиглан зөвшөөрөл олгох, хянах үйл ажиллагааг ялгамжтай болгох аргыг хуульд тусгаагүй байна. Үүнээс шалтгаалан аль ч төрлийн зөвшөөрөл авахаар өргөдөл гаргах, баримт бичиг бүрдүүлэх, түүнийг хянах, зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих бүхий л ажиллагаа нэг ижил, хүнд суртлын шалгуур, дамжлагаар явагдах нөхцөлийг бүрдүүлж байна.

Иймд зөвшөөрлийг түүний зорилго, олгох нөхцөл зэргийг харгалзан онцгой, тусгай, энгийн гэсэн 3 бүлэгт ангилах, уг ангиллаас хамаарч зөвшөөрөл олгох нөхцөл, журмыг ялгамжтай болгох шаардлагатай.

- Зөвшөөрлийг хэн олгох, шийдвэрийг хэрхэн гаргах гэх мэт асуудлыг голдуу журмаар зохицуулдаг. Яамны түвшинд сайд, агентлагийн түвшинд дарга нь зөвшөөрлийн гэрчилгээнд гарын үсэг зурдаг боловч олгох асуудлыг хэлэлцэн шийдвэрлэдэг бүтэц нь ихэвчлэн тусдаа байна. Орон нутгийн түвшинд олгодог зөвшөөрлийн нэр төрөл харьцангуй бага байна. Товчхондоо эрх шилжүүлэх журам тодорхой бус учраас эрх мэдлийн хуваарилалт хэтэрхий төвлөрсөн шинжтэй ба цахим аргаар эсхүл орон нутгийн түвшинд нэг цэгийн үйлчилгээгээр зөвшөөрөл олгоход бэрхшээлтэй байна.

Иймд хуулиар дээрх үйл ажиллагааг хялбаршуулах, шийдвэр гаргалтын шат дамжлагыг багасгах, байгууллага доторх эрх шилжүүлэлтийг дэмжих, эрх бүхий байгууллагыг орон нутаг болон захиргаа-удирдлагын доод шатанд төлөөлөн зөвшөөрөл олгодог нөхцөл боломжийг хуулиар бүрдүүлэх шаардлагатай.

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд зөвшөөрөл олгох үйл ажиллагаа, бүрдүүлэх материал, хүчинтэй байх хугацаа зэрэг зохицуулалт байгаа боловч үйл ажиллагааны журам тодорхой бус байна. Үүнээс үүдэн яам, агентлагууд журам гаргах нэрээр хэт өндөр шаардлага тавих, зөвшөөрөл авахад шаардагдах баримт бичгийг нэмэгдүүлэх, хугацаандаа хариу өгөхгүй байх, олон шат дамжлага (гарын үсэг цуглуулах) гаргаж цаг хугацаа сунжруулах зэргээр хувь хүн, хуулийн этгээдэд хүндрэл бэрхшээл учруулж байна.

Дэлхийн худалдааны байгууллагын лиценз олгох дүрмийн дагуу зөвшөөрөл олгохдоо автомат болон автомат бус аргыг баримталдаг. АНУ, Япон, Европын орнуудад зөвшөөрөл олгох бус бүртгэх системд илүү ач холбогдол өгөх хандлагатай байна.

Иймд зөвшөөрөл олгох үйл ажиллагааны нийтлэг журмыг Зөвшөөрлийн тухай хуульд, тусгайлсан журмыг салбарын хуульд тус тус тусгах хууль зүйн техник ашиглах нь зохистой. Цаашид яам, агентлагийн зүгээс зөвшөөрөл олгохтой холбоотой нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ бүхий аливаа журам батлан гаргахыг хориглох шаардлагатай.

- Зөвшөөрөл авахаар өргөдөл гаргах, түүнийг хянах, хэлэлцэх, олгох үйл явц болон олгосон зөвшөөрөл, түүнийг эзэмшигчийн талаарх мэдээлэл ил тод биш байна. Энэ нь хууль бусаар, аливаа олон нийтийн хяналтгүйгээр зөвшөөрөл олгох эсхүл олгохгүй зориуд удаах, хүнд суртал үүсэхэд нөлөөлөх гол хүчин зүйлсийн нэг болж байна. Ил тод бус байдлыг ашиглан зөвшөөрөл олголтоор өрсөлдөгчөө хязгаарладаг, тендер шалгаруулалтад нэмэлт нөхцөл болгож оруулдаг зэрэг зах зээлийн өрсөлдөөн, бизнест харш зохисгүй арга хэрэглэх явдал байсаар байна.

Иймд зөвшөөрөл, түүний олголт, эзэмшилтэй холбоотой бүртгэлийг сайжруулж, мэдээллийг ил тод, нээлттэй болгох, зөвшөөрөл олголтын үйл ажиллагаанд мэдээллийн технологийг нэвтрүүлэх, холбогдох эрх зүйн орчинг бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай.

- Хууль бусаар зөвшөөрөл олгосон, хуульд заасан хугацаанд зөвшөөрөл олгох эсэх талаар хариу өгөөгүй гэх мэтчилэн буруутай үйл ажиллагааныхаа төлөө зөвшөөрөл олгосон албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалт алга байгаа нь зөвшөөрөл олгож буй байгууллага дур зоргоороо авирлах нөхцөлийг бүрдүүлж байна.

Иймд зөвшөөрөл олгож буй байгууллага, албан тушаалтны хариуцлага хүлээх нөхцөл, тохиолдол, хариуцлагын төрөл, хэмжээг хуулиар тодорхой зохицуулах шаардлагатай.

- Зөвшөөрлийг богино хугацаатай олгодог, олгосоны дараа үндэслэлгүйгээр зөвшөөрлийг хурааж авах, түтгэлзүүлэх, хүчингүй болгох арга хэмжээ авдаг төрийн хяналт шалгалтын байгууллагын зохисгүй практик байсаар байна. Зөвшөөрөл олгох тогтолцоо тодорхой, тогтвортой болж, эрх бүхий этгээдийн эрх хэмжээ ч мөн тодорхой болж өгснөөр үүнтэй холбоотой аливаа гомдол маргааны тоо багасна.

Зөвшөөрлийн хууль тогтоомжийг шинэчлэх ажлын хүрээнд зөвшөөрлийг цуцлах, хүчингүй болгох, сунгахаас татгалзах үндэслэл, нөхцөл, журмыг хуулиар нарийвчлан зохицуулах шаардлагатай байна.

## **1.2 Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд:**

Өмнөх хэсэгт дурдсан практик хэрэгжилтийн асуудал нь дараахь бүлгийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд сөргөөр нөлөөлж байна:

| <b>Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг</b> |                                    | <b>Нөлөөлж буй хэлбэр</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |
|------------------------------------|------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1                                  | Бизнес эрхлэгч иргэн, аж ахуй нэгж | -Төрийн байгууллагаас тусгай зөвшөөрөл олгохтой холбоотойгоор нэмэлт нөхцөл, шаардлага тавих зэргээр зөвшөөрлийн төрөл, хамрах хүрээ, бүрдүүлэх баримт бичиг, хангах шаардлага нөхцөл хэт өргөн байна.<br>-Бизнес эрхлэгч иргэн аж ахуйн нэгжид дарамт учруулах, хүнд суртал, авлига үүсэх гол шалтгаан болж байгаа юм.<br>-Төрөөс хүртээмжэй, чанартай үйлчилгээг шуурхай хүртэж чадахгүй байна. |
| 2                                  | Онцлог хэрэгцээтэй иргэд           |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |
| 3                                  | Нийт иргэд                         |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |

Дээрх сөрөг нөлөөллийн улмаас шударга ёс, иргэний нийгмийн оролцоо, хяналт хязгаарлагдаж, төр, иргэн, төрийн бус байгууллагуудад давхар зардал үүсгэх, иргэдийн төрд итгэх итгэл алдагдах, хүнд суртал, чирэгдэл, дур зогоор авирлах байдлыг нэмэгдүүлж байна.

### **1.3 Асуудлыг үүсгэж буй учир шалтгаан:**

Холбогдох мэдээллийг харьцуулан дүгнэхэд Монгол Улсын хэмжээнд төрөөс олгож буй тусгай зөвшөөрөлтэй холбоотой олон бэрхшээл, маргаантай асуудал байсаар байна. Үүнд:

- Зөвшөөрлийн ангилал байхгүйн улмаас зарим зөвшөөрлийн хувьд ялгамжтай, уян хатан, хялбаршуулсан нөхцөлийг ашиглах боломжгүй байна.

- Зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээн авах, хянах, шийдвэрлэх, зөвшөөрлийн гэрчилгээнд гарын үсэг зурах бүрэн эрхийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам тодорхой бус байна.

- Зөвшөөрөлтэй холбоотой мэдээлэл ил тод, нээлттэй байж чадахгүй байна.

- Зөвшөөрөл олгож буй эрх бүхий албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалт алга байна.

- Зөвшөөрөл олгосны дараа түүнийг сунгах, түдгэлзүүлэх, цуцлах, хүчингүй болгохтой холбогдсон гомдол, маргааны тоо хэмжээ буурахгүй байна.

### **Хоёр. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг томьёолох**

#### **2.1 Зорилгыг аль болох тодорхой, хэмжих боломжтой, хүрэхүйц, бодитой байхаар томьёолно:**

2001 оны 2-р сарын 01-ний өдөр батлагдсан Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулинд олон удаагийн нэмэлт, өөрчлөлт орсноор хуулийн уялдаа холбоо алдагдаж тодорхой зохицуулалтгүйгээс шалтгаалан тусгай зөвшөөрлийн тоо эрс өсч бизнес эрхлэгч иргэн, аж ахуй нэгжид хүнд суртал ихэсжээ.

Иймд Аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх зорилтыг дараахь байдлаар тодорхойлж байна.

Зорилт: “Төрөөс бизнес эрхлэгчдэд олгож байгаа одоогийн тусгай зөвшөөрлийн тоог гурав дахин цөөрүүлж, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, хүнд суртлаас ангид байлгах” гэж томъёолж байна.

**Гурав. Асуудлыг зохицуулах хувилбарыг тогтоож, эерэг болон сөрөг талыг харьцуулах**

| Хувилбар |                                                                         | Зорилгод хүрэх байдал                                                                                                              | Зардал, үр өгөөжийн харьцаа                                                                                                          | Үр дүн                     |
|----------|-------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------|
| 1        | Тэг хувилбар                                                            | Одоогийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй.                                              | Нэмэлт зардал гарахгүй ч, сөрөг үр дагавар улам бүр нэмэгдэнэ.                                                                       | Үр дүн сөрөг               |
| 2        | Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх                 | Зорилгыг хангахгүй.                                                                                                                | Зардал тодорхой хэмжээнд гарна. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаварыг бууруулж чадахгүй.       | Үр дүн сөрөг               |
| 3        | Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх | Энэ хувилбарыг ашиглах тохиолдолд зорилгод хүрэх боломжгүй.                                                                        | Тодорхой хэмжээний зардал гарна. Гэвч асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаварыг бууруулж чадахгүй. | Дангаараа үр дүнд хүрэхгүй |
| 4        | Төрөөс санхүүгийн интервенци хийх                                       | Төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх тохиолдолд хүний нөөц, техник, технологийг бэхжүүлэх боломжтой ч зорилгыг бүрэн хамарч чадахгүй. | Тодорхой хэмжээний зардал гарна. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаварыг бууруулж чадахгүй.      | Үр дүнд хүрэхгүй           |
| 5        | Захиргааны шийдвэр гаргах                                               | Бизнес эрхлэгчдийн хамрагдах хүрээ, төрийн байгууллагын хариуцлагыг нэмэгдүүлэх, хяналт сайжрах боломж бүрдэх                      | Асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг арилгахад цогцоор нөлөөлж, сөрөг үр дагаварыг бүрэн бууруулж чадахгүй.                             | Тодорхой үр дүнд хүрнэ.    |

|   |                                      |                                                        |                                                                                                                          |           |
|---|--------------------------------------|--------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------|
|   |                                      | боловч үр дүнд төдийлөн ахиц гаргаж чадахгүй.          |                                                                                                                          |           |
| 6 | Хууль тогтоомжийн төсөл боловсруулах | Энэхүү хувилбар нь зорилгыг бүрэн зохицуулах боломжтой | Зардал гарах боловч энэ нь хувилбар нь асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлэх боломжтой. | Үр дүнтэй |

### **3.1 Харьцуулалтын үр дүнг харгалзан үзвэл дараах хувилбар илүү эерэг нөлөөлтэй байх магадлалтай байна.**

Дээрх харьцуулалтаас харахад зөвхөн “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах” хувилбар үр дүнтэй харагдаж байна.

Иймд хуулийн төслийн агуулга, зохицуулалтын хэлбэрийг өмнө тодорхойлсон зорилгын дагуу дараах байдлаар ерөнхийлөн томъёолж байна:

“Энэ хуулийн төслөөр зөвшөөрлийн ангилал, тодорхойлолт, төрөл, нэр томъёо болон зөвшөөрөл хүсэгч, эзэмшигч этгээдийн эрх, үүрэг, зөвшөөрөл олгох этгээдийн бүрэн эрх, уг эрхийг шилжүүлэх журам, зөвшөөрөл олгох үйл ажиллагааны нийтлэг журам, зөвшөөрлийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих бүтэцтэй холбоотой харилцааг зохицуулна.”

### **ДӨРӨВ. СОНГОСОН ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ**

Аргачлалын 6-д заасны дагуу сонгосон хувилбарын үр нөлөөг Аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

*Жич: Хавсралт хэсэгт Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө, Эдийн засагт үзүүлэх үр нөлөө, Нийгэмд үзүүлэх үр нөлөө, Байгаль орчинд үзүүлэх нөлөө тус бүрийн асуултуудад хэрхэн хариулсныг оруулсан болно.*

#### **4.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө;**

Хуулийн төсөл боловсруулах хувилбар нь хүний эрхэд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй.

#### **4.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө;**

Хуулийн төсөл боловсруулах хувилбар нь эдийн засагт ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй. Иргэн, хуулийн этгээдийн хувьд зөвшөөрөл авахтай холбогдон гарах албан зардал багасна. Зарим төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх, төрийн байгууллага бүр тус хуулиар тодорхой чиг үүрэг хүлээх тул улсын төсөвт бага зэргийн нөлөө үзүүлнэ.

Иймээс “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу судалж байгаа асуудал, зохицуулалтын хувилбарын онцлогоос хамааруулан зардлын тооцоог нарийвчлан хийнэ.

#### **4.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө;**

Хуулийн төсөл боловсруулах хувилбар нь нийгэмд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй. Харин бизнес эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийн хувьд эерэг өөрчлөлт авчирна.

#### **4.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө**

Хуулийн төсөл боловсруулах хувилбар нь байгаль орчинд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй.

#### **4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх.**

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна.” гэж, мөн зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.” гэж, Зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна.” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн.” гэж, мөн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн олон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” хэмээн тус тус хуульчилсан.

Иймд дээрх хувилбар нь Монгол Улсын Үндсэн хууль болон хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээнд нийцэх бөгөөд өнөөдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжийг аливаа хэлбэрээр зөрчөөгүй болно.

#### **ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ**

Аргачлалын 7-д зааснаар хувилбарын эерэг болон сөрөг талуудыг зорилгод хүрэх байдал, зардал, үр өгөөжийн харьцаа, хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө, Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж буй эсэх гэсэн шалгуураар дахин нягталж үзэж, хууль тогтоомжийн төсөл боловсруулахдаа 2 дугаар хэсэгт тодорхойлсон зорилгыг хангах, 3 дугаар хэсэгт ерөнхийлөн томъёолсон хуулийн төслийн агуулга, зохицуулах харилцааны хүрээнд зөвшөөрлийн тухай хуулийн төсөл боловсруулж, асуудлыг шийдвэрлэх боломжтой гэж дүгнэлээ.

#### **ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ**

Бусад орны эрх зүйн зохицуулалт, туршлагыг судлах хүрээнд энэ чиглэлээр өмнө хийгдсэн судалгааны мэдээлэлд үндэслэн тодорхой нөхцөлийг тодруулах зорилгоор дараахь улсуудыг сонгон авсан:

## **ДОЛОО. ЗӨВЛӨМЖ**

Энэхүү тандан судалгааны 2 дугаар хэсэгт томьёолсон зорилгод хүрэхийн тулд 3 дугаар хэсэгт хуулийн төсөл боловсруулах шаардлагатай нь тогтоогдож, уг хуулиар зохицуулах харилцааг ерөнхийлөн тодорхойлсон. Мөн 4 дүгээр хэсэгт хуулийн зохицуулалтын хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг судлахад сөрөг нөлөө гараагүй бөгөөд 5 дугаар хэсэгт зохицуулалтын хувилбарыг өмнөх шатуудад хийсэн судалгааны хүрээнд харьцуулан дүгнэхэд хуулийн төсөл боловсруулж, зохицуулах нь зүйтэй гэсэн дүгнэлт гарсан.

Иймд 6 дугаар хэсэгт гадаад орнуудын хуулийн зохицуулалтыг судалж, Зөвшөөрлийн тухай хуулиар дараахь асуудлыг нарийвчлан зохицуулах нь зүйтэй гэсэн зөвлөмжийг гаргаж байна:

1.Зөвшөөрлийн тухай хуулийн зорилт, зарчим, хуулийн үйлчлэх хүрээ, хуулийн нэр томьёоны тодорхойлолт болон бусад хууль тогтоомж, олон улсын гэрээтэй хэрхэн уялдах, хэрэглэх эрэмбийн асуудлыг тодорхойлно. Төсөлд хуулийн нэр томьёог нарийвчлан тайлбарлана. Хуулийн үйлчлэх хүрээг тодорхой зааглаж тогтоох ба нийтийн өмч болон орчин тойронд аюултай эд зүйл эзэмших, ашиглах зөвшөөрлийг энэ хуулийн төсөлд хамруулна.

2.Зөвшөөрлийн тодорхойлолт, зөвшөөрлийн баримт бичгийн хэлбэр, нэршил (зөвшөөрлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, дүгнэлт, батламж, эрхийн бичиг, тодорхойлолт гэх мэт), агуулга болон зөвшөөрлийн ангилалтыг нарийвчлан тусгана.

3.Хуулийн төсөлд зөвшөөрөлтэйгээр эрхлэх үйл ажиллагаа, эзэмших, ашиглах нийтийн өмч, эрхийн нэр төрлийг зөвшөөрлийн жагсаалтаар тогтооно. Зөвшөөрлийн жагсаалтыг хуулиар тусгайлан батална.

4.Зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд, түүний чиг үүргийг тодорхой болгоно. Жишээ нь: зөвшөөрөл олгогч нь Засгийн газар, Засгийн газрын гишүүн-сайд, эсхүл яам байх эсэхийг ялгамжтай тогтооно. Сайд зөвхөн онцгой зөвшөөрлийг зохих ажлын хэсэг, зөвлөлийн саналын дагуу олгоно. Яам буюу төрийн захиргааны төв байгууллагын хувьд тусгай зөвшөөрлийг аливаа хороо, комисс, ажлын хэсгийн хурлаар хэлэлцэхгүйгээр төрийн нарийн бичгийн дарга эсхүл түүнээс эрх олгогдсон албан тушаалтны шийдвэр, гарын үсгээр шууд олгоно.

5.Зөвшөөрөл хүсэгч, эзэмшигчид тавигдах нийтлэг шаардлага болон тэдний эрх, үүргийг хуульд тодорхой тусгана. Аж ахуйн үйл ажиллагаанд холбогдсон зөвшөөрлийг зөвхөн ашгийн төлөө хуулийн этгээд, аж ахуй эрхлэгч хувь хүнд олгох журам тогтооно.

6.Зөвшөөрөл олгох үйл ажиллагааны нийтлэг журмыг нарийвчлан хуулийн төсөлд тусгана. Үүнтэй холбогдуулан салбарын хуульд зөвхөн тусгайлсан журмыг тусгадаг болох хэрэв ийм журам байхгүй бол нийтлэг журмыг баримталдаг болно. Өөрөөр хэлбэл зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд журам баталдаг өнөөгийн нөхцлийг аль болох багасгах, хязгаарлах журмыг хуулийн төсөлд оруулна.

7.Захиргааны байгууллагын санаачилгаар зөвшөөрлийг түтгэлзүүлэх, цуцлах нөхцөл, журмыг тодорхой болгож, тусгай болон энгийн зөвшөөрлийг зөвхөн шүүхийн журмаар цуцлах, түтгэлзүүлэх дэглэмд шилжүүлэх, онцгой зөвшөөрлийг олгосон байгууллага шууд цуцлах, цуцалсны дараа шүүхэд хандаж байх зохицуулалтыг хуулийн төсөлд оруулна. Түүнчлэн зөвшөөрөл хүсэгч этгээд хуурамч бичиг баримт бүрдүүлсэн гэх мэт тохиолдолд зөвшөөрлийг хүчингүйд тооцох журам болон зөвшөөрөл цуцлагдсан, хүчингүй болсны үр дагаврыг хуулийн төсөлд тусгана.

8.Бүртгэл, лавлагаа, мэдээллийн талаар шинэ зохицуулалт бий болгоно. Мөн зөвшөөрөл мэдүүлэх, хянах, олгох үйл явцын талаархи шаардлагатай лавлагаа, мэдээллийг аливаа сонирхогч этгээд чөлөөтэй авах бололцоог хуулиар хангана.

### Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

| Үзүүлэх үр нөлөө                                   | Холбогдох асуулт                                                                                                                                                                                 | Хариулт |        | Тайлбар                                                                     |
|----------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------|--------|-----------------------------------------------------------------------------|
| 1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх | 1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх                                                                                                                                                         |         |        |                                                                             |
|                                                    | 1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх                                                                                                                                                       | Тийм    | Үгүй ✓ | Зөвшөөрөл авахад тавигдах шаардлага, шалгуурыг нийтлэг, тэгшээр хуульчилна. |
|                                                    | 1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх                                                                                                                         | Тийм    | Үгүй ✓ | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй                                              |
|                                                    | 1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх | Тийм    | Үгүй ✓ | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй                                              |
|                                                    | 1.2.Оролцоог хангах                                                                                                                                                                              |         |        |                                                                             |
|                                                    | 1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх                                                                | Тийм✓   | Үгүй   | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй                                              |
|                                                    | 1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх                                                       | Тийм ✓  | Үгүй   | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй                                              |

|                                                       |                                                                                                                                                                                                    |        |        |                                                                   |
|-------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------|--------|-------------------------------------------------------------------|
| 1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага |                                                                                                                                                                                                    |        |        |                                                                   |
|                                                       | 1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх                                                                                    | Тийм√  | Үгүй   | Төрийн байгууллагын хүнд суртал арилна.                           |
|                                                       | 1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмийн талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх                                   | Тийм √ | Үгүй   | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй                                    |
